

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО


ТӨРИЙН АЛБАНЫ ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НБД
М.БАТЖАРГАЛ

Цаг уур, орчны шинжилгээний газрын Ёс зүйн дэд хороо

Долоон гишүүний бүрэлдэхүүнтэй

1. Н.Энхмаа /Дэд хороон дарга/
2. Д.Батдорж
3. Ж.Энхчимэг
4. М.Лхагвасүрэн
5. О.Оюунчимэг
6. Э.Энхзаяа
7. М.Батжаргал /НБД/


ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 12 өдөр Дугаар А/08 Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг
батлах тухай


Монгол улсын "Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.4.1 дэх заалт, тус газрын албан хаагчдын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дор дурдсанаар баталсугай.

Дарга:	Н.Энхмаа	-Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийг хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Д.Батдорж	-Архив, мэдээллийн сангийн хэлтсийн дарга
	Ж.Энхчимэг	-Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	М.Лхагвасүрэн	-Мэдээллийн технологи, нислэгийн цаг уурын үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
	О.Оюунчимэг	-Урьдчилсан мэдээлэх үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
	Э.Энхзаяа	-Тусгай хэрэгцээний мэдээ хариуцсан ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга:	М.Батжаргал	-Мэдээллийн студи хариуцсан ерөнхий инженер

2. Ёс зүйн дэд хорооны ажиллах хөтөлбөрийг боловсруулж батлуулахыг дүрэм, журмыг хэрэгжүүлэх ажлыг тус газарт зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Н.Энхмаа)-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын "Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах тухай" 2023 оны А/65 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ
ХЭЛТСИЙН ДАРГА  О.ОЮУНЖАРГАЛ

151240823

Хуулийг хэрэгжүүлэх, тайлбарлан таниулах



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ

2023.05.04 ӨДӨР БАТЛАГДСАН

Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал нь анх удаа хуулчлагдсан
хэлбэрээр мөрдөгдөж явна

Хуулийн зорилго

Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх эрхэм зорилгоо ухамсарлаж, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлж, төрөө дээдлэх ард түмний итгэлийг бэхжүүлэхэд энэ хуулийн зорилго оршино.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль

- **Нэгдүгээр бүлэг:** Нийтлэг үндэслэл /5 зүйл/
- **Хоёрдугаар бүлэг:**Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлага /3 зүйл/
- **Гуравдугаар бүлэг:**Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа /1 зүйл/
- **Дөрөвдүгээр бүлэг:**Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал эрхлэх эрх бүхий этгээд, бүрэн эрх /4 зүйл/
- **Тавдугаар бүлэг:** Гомдол, мэдээлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх /2 зүйл/
- **Зургадугаар бүлэг:** Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх /3 зүйл/
- **Долоодугаар бүлэг:** Бусад /1 зүйл/

Ёс зүйн дэд хорооны зорилт нь

- Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт хийх
- Зөрчил гарч байгаа нөхцөл байдлыг олж тогтоох,
- Ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах
- Байгууллагын албан хаагчтай холбоотой гомдол мэдээллийг хянаж шийдвэрлэх
- Олон нийтэд мэдээлэх

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж

3.1.Төрийн албаны хаагчийн ёс зүйн хууль тогтоомж нь

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Төрийн албаны тухай хууль,
- Эрүүгийн хууль,
- Авлигын эсрэг хууль,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,
- Захиргааны ерөнхий хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Тайлбар

Нийтлэг шаардлага	Үйлдэл, эс үйлдэхүй	Зохицуулж буй хууль
Авлигаас ангид байх	Авлигын гэмт хэрэг	Эрүүгийн хууль
Сонирхлын зөрчил гаргахгүй байх	Бэлэг авах, давхар ажил эрхлэхийг хориглох, оффшор данс нээх зэрэг захиргааны зөрчил	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
Өөрийн өмч хөрөнгийг мэдүүлж байх	Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах захиргааны зөрчил	Авлигын хууль
Илт хууль бус шийдвэр гаргахгүй байх	Эрх олгогдоогүй байхад дур зоргоороо шийдвэр гаргах захиргааны зөрчил	Захиргааны Ерөнхий хууль
Төрийн албаны үнэт зүйлс, эрхэм зорилгод харш үйлдэл гаргахгүй байх	Төрийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй, үр ашигтай, чирэгдэлгүй хүргэх, төвийг сахих, ялгаварлан гадуурхахгүй байх улсын болон төрийн байгууллагын нэр хүндийг гутаах аливаа үйлдэл гаргах зэрэг сахилгын зөрчил	Төрийн албаны тухай хуулийн 37, 39
Байгууллагын дотоод дүрэм, журмыг сахих, соёлд хүндэтгэлтэй хандах	Цаг ашиглалт, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, байгууллагын эд хөрөнгийг хувьдаа ашиглах сахилгын зөрчил, хамт олны дунд бүдүүлэг зан авир гаргах, багаар ажиллахгүй байх зэрэг ёс зүйн дүрэмд заасан зөрчил	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн дотоод журам Нийтлэг ёс зүйн дүрэм

1. ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

№	Албан хаагч, этгээд	Байгууллагын тоо	Албан хаагчийн тоо
1	Төрийн албан хаагч - Төрийн улс төрийн албан хаагч – 3759 - Төрийн тусгай албан хаагч – 47158 - Төрийн захиргааны албан хаагч -22023 - Төрийн үйлчилгээний албан хаагч- 152265	4232	225205
2	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан	103	103
3	Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч		8928
4	Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал	1	5
5	Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн	1	10
6	Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан		
	Нийт	4337	234251

2.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 7 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН

- ард түмэнд үйлчлэх;
- мэргэшсэн, тогтвортой байх;
- улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;
- Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;
- төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;
- ил тод байх;
- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- захирах, захирагдах ёсыг баримтлах.

Нийт 8 зарчим

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

- хүнлэг, энэрэнгүй байх;
- үнэнч, шударга байх
- хариуцлагатай байх;
- манлайлах;
- хамтач байх.

5 зарчим

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА

Ёс зүйн нийтлэг хэм хэмжээ

- ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх;
- зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх ;
- хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
- албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх
- төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын нөлөөллөөс ангид байх;
- төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх
- албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх
- байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх
- албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх
- багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах

10 нийтлэг хэм хэмжээ

Ёс зүйн нийтлэг шаардлага

- Ёс зүйн нийтлэг шаардлага
 - 1.Нийтлэг үүрэг
 - 2.Хориглох зүйлээс бүрдэнэ.
- **Ёс зүйн нийтлэг үүргийг зөрчсөн тохиолдолд ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж ёс зүйн хариуцлага хүлээлгэнэ.**

2 шаардлага

НИЙТЛЭГ ҮҮРЭГ

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг

18 үүрэг

- Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлд заасан үүрэг

3 үүрэг

- иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх
- эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах
- бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх
- бусдын ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх
- бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хясан боогдуулахгүй байх
- албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх
- албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.

7 нийтлэг үүрэг

ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан хориглох зүйл

18 хориглолт

- Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд заасан хориглох зүйл

8 хориглолт

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалт
- 39 хориглолт

- төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах
 - удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих
 - хүний эмзэг болон хувийн мэдээллийг бусдад дамжуулах, гутаах
 - албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, буруу, дутуу мэдээлэл, тайлбар өгөх зэргээр удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд нөлөөлөх
 - үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох, үйлдэл хийх
 - соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах
 - албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх
 - албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх
- 8 хориглолт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДЛЫГ ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД - ИНСТИТУЦИ

1. Ёс зүйн хороо

- Төрийн албаны зөвлөлийн дэргэд ажиллах
- 9 гишүүний бүрэлдэхүүнтэй /ТАЗ-ийн 5 гишүүн, орон тооны бус 4 гишүүн/

2. Ёс зүйн дэд хороо

- Төрийн байгууллагын дэргэд ажиллах
- Албан хаагчдын тооноос хамаараад 3-7 гишүүний бүрэлдэхүүнтэй.

3. Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХАРЬАЛАН ШИЙДВЭРЛЭХ БАЙГУУЛЛАГА

№	Харьяалан шийдвэрлэх байгууллага	Байгууллагын тоо	Албан хаагчийн тоо
1	Ёс зүйн хороо	68	188
2	Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо	673	2387
3	Төрийн байгууллагын Ёс зүйн дэд хороо	4232	222648

№	Шийдвэрлэх байгууллага	Байгууллага		Албан хаагчийн тоо
1	Ёс зүйн хороо	1	Төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтан	169
		2	Засгийн газрын дэргэдэх болон төрийн байгууллагын Ёс зүйн дэд хорооны харьяалалд хамаарахгүй төрийн байгууллагын удирдах албан тушаалтан	14
		3	Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал /АСХ 4.1.4/	5
2	Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн хороо дэд	1	Эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтан	2274
		2	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан /АЭХ 4.1.3/	103
		3	Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан /АЭХ 4.1.5/	
		4	Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн /АЭХ 4.1.5/	10
3	Төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо	1	Тухайн байгууллагын албан хаагч Тухайн байгууллагын болон харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан	222648

ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

- “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлэх
- Төрийн албаны Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо систем дэх “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт” систем
- Ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчил арилгах арга хэмжээ авах
- Ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд мэдээлэх
- Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа
- Арга зүйн зөвлөгөө өгөх

Томилох эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх

12.1.Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

12.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

12.1.2.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах;

12.1.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

12.1.4.ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тайлбар, баримтыг Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороонд гаргаж өгөх;

12.1.5.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтэд үндэслэж, зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн хуульд өөрөөр заагаагүй бол ёс зүйн хариуцлага хүлээлгэх;

12.1.6.ёс зүйн хариуцлага хүлээсэн этгээдийн шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, Ёс зүйн хороонд тайлагнах;

12.1.7.Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

12.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

Дэд хорооны бүрэн эрх

- 13.3.1.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, **дүгнэлт гаргах**;
- 13.3.2.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;
- 13.3.3.харьяа байгууллага, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх;
- 13.3.4.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;
- 13.3.5.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх;
- 13.3.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;
- 13.3.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

БАТАЛГАА

- 13.4.1. гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах;
- 13.4.2. хуралдааны үед үүрэгт ажлаас түр чөлөөлөгдөх;
- 13.4.3. шийдвэрийн улмаас бусдын дарамт, шахалтад өртөхөөс хамгаалуулах.

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ

- Ёс зүйн Хороо, Дэд хороо/30 хоног/ - Дүгнэлт
- Томилох эрх бүхий этгээд - Ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэр
- Дүгнэлт – эс зөвшөөрвөл – Харьяалах дээд шатны байгууллагын Дэд хороо, Хороо
- Шийдвэр – эс зөвшөөрвөл – Шүүх

ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА

1. Ёс зүйн хариуцлага:

- гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;
- өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;
- байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;
- Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах.

1. Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг сайн дураар хүлээх

- Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТАЛААР ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

- Албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулах
- Албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх

ЖУРАМ

1. Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр баталж, мөрдүүлнэ.

2. Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо

- “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм” Байнгын хорооны тогтоолоор баталж, мөрдүүлнэ.

2. Ёс зүйн хороо

- “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”

- “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнд хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”

Ёс зүйн алдаа гаргасан албан тушаалтны үйлдэл болон эс үйлдэхүйд гомдол гаргавал хаана, хэнд, ямар хэлбэрээр гаргах вэ?

- 14.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг дараах харьяаллын дагуу шалгаж, шийдвэрлэнэ:
 - 14.3.1.Ёс зүйн дэд хороо өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьяалах байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны;

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**